**Ашиглах** | Шинжилгээний төлбөр болон мэдээлэх үүргээс чөлөөлөх талаар мэдэгдэл - Гадаадын иргэдэд хамааралтай.

□ Корона 19-ын шинжилгээ өгөх шаардлагатай тохиолдол

① Эмчийн дүгнэлтээр шалтгаан тодорхой бус уушгины хатгалгаа туссан зэрэг корона19-ын халдвар авсан байж болзошгүй хүн

② Гадаадын оронд зорчиж байсан ба БНСУ-д орж ирсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор халуурах(37.5℃ -ээс дээш) буюу амьсгалын замын шинж тэмдэг (ханиалгах, амьсгалахад хүндрэлтэй байх зэрэг) илэрч буй хүмүүс

③ Корона Вирусын халдвар 19- ийн олон нийтийг хамарсан дотоодын дэгдэлттэй хамааралтай бөгөөд 14 хоногийн дотор халуурах(37.5℃ -ээс дээш) буюу амьсгалын замын шинж тэмдэг (ханиалгах, амьсгалахад хүндрэлтэй байх зэрэг) илэрч буй хүмүүс

## □ Мэдэгдэл

① Дээрх нөхцөл байдлуудаас үүдэн шинжилгээ өгөх тохиолдолд иргэний харьяалал, оршин суух зөвшөөрөлтөй эсэхээс үл хамааран БНСУ-н иргэнтэй нэгэн адилаар шинжилгээний төлбөр авахгүй.

Шинж тэмдэг илэрвэл 1339 лавлах төвтэй холбогдон мэдээлэл авч, эрүүл мэндийн төв болон ойролцоо шинжилгээ авч буй газарт хандана уу.

② Оршин суух эрхгүй ч (хууль бус оршин суугч), корона19 халдварт өвчний шинж тэмдэг илэрэн эмнэлгийн байгууллагад эмчлүүлсэн тохиодолд Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд мэдээлэхгүй ба дайчлан баримчилгаанаас түтгэлзүүлнэ.

□ Корона19 халдварт өвчний шинж тэмдэг зэрэг мэдээллийг 1339 лавлах төвтэй холбогдон авч, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албантай холбоотой санал гомдол болон ахуй амьдралын мэдээллийг Гадаад иргэдийн нэгдсэн мэдээллийн төв 1345 дугаарт холбогдон авах боломжтой.

※ 1339 лавлах төвтэй холбогдон мэдээлэл авж болно, шаардлагатай тохиолдолд гурвалсан холболтоор орчуулага хийлгэх боломжтой.

□ 1339 (1345 эсвэл 1330-тай холбоно) Гадаад хэлнээр үйлчилгээ үзүүлэх цаг, төрөл

| Утасны дугаар | Ажлын цаг | Хэл |
|---|---|---|
| **(☎1345)**<br>**Хууль зүйн яам Гадаад иргэдийн нэгдсэн мэдээллийн төв** | 24 цаг | Англи, Хятад |
| | 09:00~18:00 | Япон, Вьетнам, Тайланд, Малайз / Индонез, Орос, Монгол, Бангладеш, Пакистан, Балба, Камбож, Мьянма, Франц, Герман, Испани, Филиппин, Араб, Шри-Ланка |
| **(☎1330)**<br>**Солонгосын Аялал жуулчлалын корпораци Аялал жуулчлалын мэдээллийн төв** | 24цаг | Англи, Хятад, Япон |
| | 08:00~19:00 | Вьетнам, Тайланд, Малайз / Индонез, Орос |
| **(☎1577-1366)**<br>**Солонгосын эрүүл гэр бүлийг дэмжих хүрээлэн Данури төв 1577-1366** | 24 цаг | Англи,Хятад,Вьетнам, Филиппин (Тагалог), Камбож (Хмер), Орос, Монгол, Япон, Тайланд, Лаос, Узбек, Балба |

□ Орчуулгыг Данури 1577-1366 хийв.